

God's Simple Plan of Salvation taken from 1 Иохан

Introduction

1 Иохан 5:13 Та нар мөнх амьтай гэдгээ мэдээсэй гэсэндээ би Бурханы Хүүгийн нэрд итгэдэг та нарт эдгээр зүйлийг бичсэн.

1. Бурханаас ирэх уучлал нь хэрэгтэй гэсэн байдаг.

1 Иохан 1:8 Хэрэв бид нүгэлгүй гэж хэлбэл өөрсдийгөө мэхэлж байгаа бөгөөд бидний дотор үнэн алга.

1 Иохан 5:16-17 Хэрэв хэн нэг нь үхэлд хүргэхгүй нүгэл үйлдэж байгаа ах дүүгээ харвал, залбиран гуй. Тэгвэл үхэлд хүргэхгүй нүгэл үйлдэгсдэд амийг Тэр өгнө. Үхэлд хүргэх нүгэл гэж бий. Үүний төлөө залбир гэж би хэлэхгүй. Зөвт бус байдал нь бүгдээрээ нүгэл мөн. Үхэлд хүргэхгүй нүгэл гэж бий.

1 Иохан 3:6 Түүний дотор байгч хэн ч нүгэл үйлддэггүй. Нүгэл үйлддэг хэн ч Түүнийг үзээгүй, мэдээгүй.



We are all sinners!

2. Нүглийнхээ үр дүнд бид мөнхийн үхлийг үүрээд байсан юм. Бурханы Өөрийн төгс төлөвлөгөөний дагуу

1 Иохан 5:19 Бид Бурханых, харин бүх ертөнц нь муунэгний дотор байдгийг мэднэ.

1 Иохан 5:12 Хүүтэй хүнд амь бий. Бурханы Хүү байхгүй хүнд амь байхгүй.

1 Иохан 3:15 Ах дүүгээ үзэн яддаг нэг нь алуурчин мөн. Ямар ч алуурчны дотор мөнх амь байдаггүйг та нар мэднэ.

3. Есүс загалмай дээр үхэхдээ бидний үхлийн шийтгэлийг авсан юм.

1 Иохан 4:10 Бид Бурханыг хайрласан бус, харин Тэр биднийг хайрлаж, бидний нүглийн төлөө Хүүгээ эвлэрүүлэл болгон илгээсэн билээ. Үүнд хайр байгаа юм.



Christ died for sinners!

1 Иохан 4:2-3 Бурханы Сүнсийг та нар үүтээр мэднэ. Есүс Христ махан биеэр ирснийг хүлээн зөвшөөрөгч сүнс бүр Бурханаас ирсэн бөгөөд Есүсийг хүлээн зөвшөөрдөггүй сүнс бүр Бурханаас ирээгүй. Энэ бол Христийг эсэргүүцэгчийнх бөгөөд та нар түүнийг ирж байна гэдгийг сонссон ба тэр эдүгээ дэлхийд хэдийнээ байж байна.

1 Иохан 5:11 Гэрчлэл нь энэ байна. Бурхан бидэнд мөнх амийг өгсөн бөгөөд энэхүү амь нь Түүний Хүүтийн дотор байна.

4. хүлээн зөвшөөрвөл таны гэм нүглүүд уучлагдах болно.

1 Иохан 5:14-15 Хэрэв бид Түүний хүслийн дагуу юуг ч гуйвал, Тэр биднийг сонсдог гэдэг нь Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм. Бид юуг ч гуйсан, Тэр биднийг сонсоно гэдгийг бид мэдвэл, бид Түүнээс гуйснаа авсан болохыг мэднэ.

Romans 10:9-10;13 Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт

байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ. Учир нь «Эзэний нэрээр дуудах хэн ч аврагдах болно».



Та авралд хүрэх Ромын замаар явмаар байна уу? Хэрэв тийм бол Бурханд хандан залбирах энгийн нэгэн залбирал энэ байна. Үүнийг та зүрх сэтгэлээрээ хэлсэнээр Есүс Христэд өөрийн авралыг даатгаж байгаагаа Бурханд илэрхийлж буй хэрэг юм. Энэ залбирлыг хэлсэнээр ч юм уу эсвэл өөр ямар нэгэн залбирал уншсанаар та аврагдахгүй. Зөвхөн бидний гэмийг уучлах чадалтай Есүс Христэд итгэх итгэл л аварч чадах билээ. Энэхүү залбирал нь Бурханд хандан өөрийнхөө итгэлийг илэрхийлэн уучлалыг өгсөнд нь Түүнд талархах энгийн залбирал юм.



“Бурхан минь,

би Таны эсрэг гэм нүглийг үйлдэж, үүнийхээ төлөө шийтгүүлбэл зохистой нэгэн билээ. Гэвч Есүс Христ миний авах ёстой шийтгэлийг үүрч, Түүнд өгсөн итгэлээр дамжуулан би уучлалыг авсан билээ. Би гэм нүглээсээ эргэн, бүх итгэлээ Танаас ирэх авралд тавьж байна. Таны өгсөн гайхамшигт энэрэл болон уучлалд тань баярлалаа! Амээн!”